

БАТЛАВ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА
А.БАТБАЯР

МОНГОЛЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ
ТҮҮХТ 95 ЖИЛИЙН ОЙГ УГТАЖ ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН
ГАЗРААС НИЙТ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ДУНД ЗОХИОН
БАЙГУУЛАХ УРЛАГИЙН НААДМЫН УДИРДАМЖ

2016.04.05

Төв аймаг Зуунмод сум

Зорилго: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Соён гэгээрүүлэх ажил зохиох" /код 939/ журмыг баримтлан Цагдаагийн газрын хэмжээнд урлагийн үйл ажиллагааг өрнүүлэх, урлагийн авьяастаныг тодруулах, Цагдаагийн газар алба хаагчдыг олон нийтэд сурталчлах, хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдүүлэхэд оршино.

Урлагийн наадмыг зохион байгуулагч: Төв аймаг дахь Цагдаагийн газар

Нэг. Урлагийн зохион байгуулалт

1. Урлагийн наадмыг Цагдаагийн газрын тасаг албадын хүрээнд 2016 оны 4 дүгээр сарын 22 өдөр зохион байгуулна.
2. Зөвхөн тухайн тасаг, албадын алба хаагчид оролцоно.

**Хоёр. Урлагийн наадмын төрөл түүнд
тавигдах нийтлэг шаардлага**

1. "Гоцлол дуу" номинаци

Тасаг албадын 1 шилдэг дуучин энэ төрөлд оролцоно. Энэ төрөлд оролцох алба хаагчид ардын, зохиолын, эстрадын дууг амьд хөгжимтэй, бичлэг /фонограмм-/тэй дуулж болно. Өөрийн хоолойн онцлогт тохируулж дууны сонголтыг зөв хийсэн байх шаардлагатай.

2. "Хамтлаг болон харилцаа дуу" номинаци

Энэ төрөлд 2-7 хүний бүрэлдэхүүнтэй оролцоно. Чөлөөт сонголтоор хамтлаг, харилцаа дууны онцлогийг илэрхийлж дуулах шаардлагатай.

3. "Гоцлол бүжиг" номинаци

Чөлөөт сонголттой, оролцогчийн хөдөлгөөний эвсэл, техник, ур чадвар илэрхийлэл зэргийг харгалзан дүгнэнэ.

4. "Хамтлаг бүжиг" номинаци

2 ба түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй чөлөөт сонголттой, оролцогчдын хөдөлгөөний эвсэл, ансамбль, техник, ур чадвар, утгын илэрхийлэл зэргийг харгалзан дүгнэнэ.

5. "Ардын язгуур урлаг" номинаци

Монгол үндэсний язгуур шинжийг илэрхийлсэн биет бус соёлын өвүүдээс нийтлэг байдлыг харгалзаж оруулсан дараах төрлүүдээс сонголт хийж оролцоно.

Үүнд: тууль, ерөөл, магтаал, дайралцаа, гийнгоо, морь бөхийн цол, хөөмэй, исгэрээ, /унзад хархираа/ цуур, хэл хуур, хулсан болон тэмэр хуур, морин хуурын татлага, домбрь, ертөнцийн гурав, бэлгэ дэмбэрэлийн үгс, оньсого, зүйр

цэцэн үгсийн зохиомж, уран нугаралт, бие биелгээ зэргээр зохиомжлон оролцено.

6. "Гоцлол болон цөөхүүл хөгжим"

Оролцогчид гоцлол болон цөөхүүл хөгжимчдөд зориулсан бүтээлийг сонгож, хөгжимдөх ур чадвартай хослуулан тоглоно. Хамсрах хөгжим /фонограмм/-тэй байж болно.

Хоёр. Урлагийн наадмыг шалгаруулах журам

1. Урлагийн наадмын шүүгчид мэргэжлийн байгууллагын бүрэлдэхүүнтэй байна.

Гурав. Урлагийн наадмын шагнал

- 1-р байр- Урлагийн наадамд оролцсон алба хаагч бүрийг цалингийн 20% шагнах, тасгийг Дорноговь аймаг дахь "Хамрын хийд" рүү аялах эрх, **Хонь**.
- 2-р байр- Наадамд оролцсон алба хаагчдыг цалингийн 15% шагнах,
- 3-р байр- Наадамд оролцсон алба хаагчдыг цалингийн 10% шагнаж урамшуулна.

БОЛОВСРУУЛСАН: СЭТГЭЛ ЗҮЙЧ, ЦАГДААГИЙН
ДЭСЛЭГЧ **Г.Ууланцээрт** Г.УУГАНЦЭЦЭГ

ХЯНАСАН: ТӨЛӨВЛӨЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ  **Б.АНХБААТАР**